ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтад заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/236, 2022 оны А/355 дугаар тушаалаар Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Тус ажлын хэсэгт холбогдох төрийн болон төрийн бусад байгууллагуудаас гадна, олон нийтийн төлөөллийг оролцуулж, хамтран ажилласан.

Гэр бүлийн тухай хуулийн төслийн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу нийт 10 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд дараах оролцогчдыг хамруулсан. Үүнд:

- Хяналт, давж заалдах, анхан шатны шүүхийн шүүгчид болон эвлэрүүлэн зуучлагчид;
- Монгол Улсад суугаа гадаад улсын элчин сайдын яамны төлөөлөл;
- Хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагын төлөөлөл;
- Гэр бүл, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын төлөөлөл;
- Тус хуулийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагын албан хаагчид;
- Олон нийт (хөгжлийн бэрхшээл, ахмад настан, эцэг, эхийн төлөөлөл гэх мэт).

Хэлэлцүүлэгт хүүхдийн эрхийг хамгаалах, тэтгэмжийн асуудал, гэрлэлтийн гэрээ, гэрлэгчдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг саналууд ирсэнийг хуулийн төсөлд тусгасан.

Харин гэр бүлээс гадуурх харилцааг зохицуулах, гэр бүлд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх, хүүхдийн тэтгэлгийн сан байгуулах талаар өгсөн саналыг хуулийн төсөлд тусгаагүй болно. Учир нь энэхүү асуудлууд нь гэр бүлийн тухай хуулиар зохицуулагдах боломжгүй байна.

Мөн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудсанд байршуулж, олон нийтээр хэлэлцүүлсэн болно.

Д/д	Нэр	Санал	Саналыг тусгасан байдал
	Г.Төгссаруул	Гэр бүлээс гадуурах харилцаанд орсон этгээдэд ял эрүүгийн хариуцлага оногдуулдаг зүйл заалт оруулмаар байна.	Гэр бүлээс гадуурах харилцаанд орсон этгээдэд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
	Ариунаа	Гэр бүлийн гишүүн эхнэр, нөхөр гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэвэл авар арга хэжээ, айл гэр санаатай, санамсаргүй үймүүлсэн этгээдэд	Гэрлэгчийн буруутай үйлдэлээс шалтгаалж нөгөө талдаа хохирол

		хариуцлага тооцох, үр хүүхдээ үл хайхарсан хүчирхийлэл үйлдсэн этгээдэд авах арга хэмжээг маш чанга болгох хэрэгтэй байна.	учруулсан бол хохирлоо барагдуулах нэхэмжлэл гаргах боломжийг хуулийн төсөл тусгасан.
	Билэгмаа	Араар тавилтыг чангатгах Хүүхдийн тэтгэмжийг чангатгах	Хуулийн төсөл хүүхдийн тэтгэлгийг хэмжээг өөрчлөх асуудлуудыг тусгасан.
	Д.Мөнх-Эрдэнэ	5.2.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө сайн дурааараа, харилцан тохиролцсоны үндсэн дээр эрүүл мэндийн шинжилгээ өгч, эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно./эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байна./ 5.2 Гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдсан байна. 5.3.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно.5.3 авсан байна.	
	Сансартуяа	Гэр бүл саллаа хаяад явсан эцэг эхэд үүрэг хариуцлага гэж алга.Хүүхэдтэйгээ уулзахгүй зугтаад хүүхэдтэй гэдгээ мэдэхгүй юу хүүхэд гээд явж байна.Энэ хуульдаа хүүхэдтэйгээ уулзах харилцаа үүсгэх талаар оруулаарай.Гадаадад 7 хоногт тэдэн өдөр уулзах гээд хариуцлагын үүрэг оруулсан байдаг юм байналээ.Монголд саллаа тэр хүүхэд өнчин хүүхэд шиг л өсөж байна.Одоо нийгэмд муухай жигшүүрт хэрэг их гарч байгаа үед салсан эр эм хүнтэй сууж зугаацаж жаргаад явдаг хүүхэдтэй үлдсэн хүмүүс нь ажлын мал шиг зүтгэж үр хүүхдийнхээ ирээдүйд анхаарч явж байна.Би хуулийн хүн биш болохоор өөрийнхөө бодит байдлыг бичиж байна.Бодитой ард иргэд салаад хаягдсан эцэг эх хүүхдүүдэд бодитой хууль гаргаад өгөх.	Саналыг тусгасан
	99096795	Цалингаас өөр орлогогүй гээд өчнөөн бизнэс хийгээд явж байгаа хүмүүс зөндөө орлогоо нуун дарагдуулж үр хүүхдээ хүн чинээ тооцохгүй эцэг эх байна.Энэ хууль өмнөх 1999 оны хуультай чинь адилхан байна.Салсан	Саналыг тусгасан

		хүмүүст үр хүүхдийнхээ төлөө үхэн хатан амьдарч байна.Хариуцлага хүлээх хүмүүс нь иймэрхүү хуулиас чинь болж оодорч байна.Гэр бүл салалт Монгол шиг 3 сая гаруй хүн амтай оронд дэндүү их байна.Манай хүүхэд 7настай жил бүр сургуулийн төлбөрийн талийг нь төлүүлэх гэж шүүхэд хандаж байна.Ухамсраараа өгөхгүй заавал шүүхэд хандаж байж олж авч байна, энийг хүртэл тусгаж өгөх.	
7	Сансартуяа	Шинэ хуулийн төсөлдөө өөрчлөлт шинэчлэлтийг хийж ард иргэд гэр бүлийн үнэ цэнэтэй сайн хууль гаргаарай.Хөрөнгөө нууж нийгмийн даатгал доод хэмжээгээр төлж хүүхдийн хариуцлагаас зугтаж байгаа хүмүүстэй хатуу хууль гаргаж болдоггүй юмуу.Гэр бүл гэдэг чин улс нийгмийн гол үнэт зүйл биздээ тэтгэлэг бол арай л доогуур байна.Өөрсдөдөө хэрэгтэй хууль гаргадаг шигээ ард иргэддээ хамгийн хэрэгтэй энэ хуулиа сайн бичээд батлаад өгөөч.	Саналыг тусгасан
8	Сансартуяа	Энэ хуулийг уншиж үзлээ.Тэтгэмж төлж байгаа хүнд давуу тал их бичсэн байна.Тэтгэмжийн хэмжээг өндөр тавьж гэр бүл салалт багасна.Цалингийн доод хэмжээгээр нийгмийн даатгал төлж тэрнийхээ 50 хүрэхгүй хувийг төлөөд явж байгаа хүмүүс их байгаа.Шаардлага өндөр байх тусам хариуцлагаа мэднэ.Өөрчлөлт гэж хийсэн юм байхгүй байна шүү дээ.Би өөрөө сар бүр 108500 авдаг энэ мөнгө одоо нийгэмд хүүхдийн сурч боловсрох хоол хүнсэнд өмсөх хувцсыг нь авах мөнгө үү.Ийм зүйл биччихээд шинэчилсэн найруулга гэж хэлэхгүй байгаасай.Доривтойхон сайн хууль гаргаач Хууль шинэчлэгдэхийг их хүлээж байгаа ээж аавууд байгаа.Хариуцлагатай сайн хууль гаргаад гуйж байна.	Саналыг тусгасан
9	Болортуяа	Гэр бүлийн гадуурх явдалд хариуцлага үүрүүлдэг болмоор байна.	Гэр бүлээс гадуурах харилцаанд орсон этгээдэд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.

12	Б.Мөнхзул	Гэр бүлийн гишүүдийнх нь эрүүл мэнд, сэтгэцэд учирсан хохирлыг тооцоод хуульчлахад болно. Ялангуяа гэр бүлтэйг нь мэдсээр байж явж байгаа тэр хүнд эрүүгийн хариуцлага оногдуулаа ёстой.	Гэр бүлийн гишүүдийнх нь эрүүл мэнд, сэтгэцэд учирсан хохирлыг нэхэмжлэх зохицуулалтыг тусгасана.
13	Номин	Гэр бүлээс гадуур харилцаа үүсгэсэн 2 хүнд хариуцлага хүлээлгэж хуулийн дагуу шийтгэдэг байх	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
14	Уртнасан	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн сэтгэлзүйд анхаарах тухай заалтыг маш сайн дэлгэрэнгүй оруулж өгөх, ижил хүйстэн гэр бүлийг зөвшөөрдөг болгох	Гэрлэлт цуцлах үед сэтгэл зүйчийг оролцуулах зохицуулалтыг тусгасан. ижил хүйстэн гэр бүлийг зөвшөөрөх асуудал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасантай нийцэхгүй тул тусгаагүй.
15	Б.Цэрэндолгор	эр бүлээс гадуурх харилцааг хуульчлах	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
16	Мандах	Бага насны хүүхдийг зодох, гэмтээхэд гэмтлийн зэргийн дагуу хорих эсвэл дохиололтой мэдрэгч аппарат зүүлгэж хүүхдэд дахин ойртвол хорих хугацааг нэмэх зэрэг хүүхдийг хамгаалах. Зоддогийг мэдсээр байж тавьж явуулсаар олон хүүхэд үхтэл айж, улам их зодуулж, зарим амиа алдаж бна. Зодсоор байгаад алж бна гэж төсөөл үнэхээр аймшигтай.	Тус хуулийн төслөөр зохицуулах харилцаа биш тул саналыг тусгаагүй.
17	Баярмаа	Гэр бүлийн үнэ цэнийн талаар мэдээлэл сайн өгөх.	Саналыг тусгасан
18	Алтансувд	Гэр бүлээс гадуурх харилцаанд хариуцлага тооцдор болох.	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн

			төсөлд тусгаагүй болно.
19	Ариунтуяа	Гэр бүлийн гадуурх харилцаанд хариуцлага тооцдог болох.	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
20	Ариунболор	Гэр бүлээс гадуурх харилцаанд хуулийн зохицуулалт хийх	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
21	Эрдэнэбулаг	Гэр бүлийн тухай хуулийн 3.3.Монгол Улсад эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна. 9.3.6.бие биедээ үнэнч байх үүргийг хуулиар заасан байна. мөн энэ заалт нь нууц амраг, араар тавилт зэргийг хуулиар хориглосон зарчим байна. Энэ заалтыг зөрчсөн тохиолдолд хуулийн ямар хариуцлага хүлээлгэх вэ. жилд дундажаар 6000 гэр бүл гэр бүл цуцлуулах асуудлаар шүүхэд хандаж, 10000 хүүхэд хангас өнчин болж, гэмт хэргийн обьект, хохирогч болж байна. 94.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ. гэж заажээ. Зөрчлийн болон эрүүгийн хуулийнд дээрх заалтыг зөрчсөн бол хуулийн ямар хариуцлага хүлээлгэх заалт байна уу. жишээ нь 9.3.6.бие биедээ үнэнч байх; үнэнч байгаагүй бол эрүүгийн хууль, зөрчлийн хуулинд дээр ямар хуулийн хариуцлага байна. энэ заалтанд хэн хяналт тавих байх... гэр бүл хуурсан гэх гомдолыг хаана гаргах нь тодорхойгүй байна. Гэр бүл салалтын хамгийн том хохирогч нь хүүхэд болохоор хүүхдийн эрх ашигт санаатайгаар халдаж, гэр бүл үймүүлсэн этгээдэд хуулийн хариуцлага тооцох эрхзүйн үндэслэл нь энэ хуульд байхгүй байна.... гэж дүгнэж байна.	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
23	Өнөртуяа	Гэр бүлийн аль нэг гишүүн нь гэр бүлээс гадуур харилцаа үүсгэсэн болон гэм буруутай 2 хүн асуудал үүсгээгүй гэр бүлийн гишүүнд тодорхой хэмжээний	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн

		өндөр дүнгээр төлбөр төлдөг байлгах талаар тусгамаар байна. Ийм заалт байхгүй учраас үүнээс үүдсэн харилцаанаас болоод хүүхдүүд их хохирч байна. Энэ хуульд тэр заалтууд байхгүй учраас хүүхдийн хойд аавууд их гэмт хэрэг үйлдэж байна	зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
24	Өнөртуяа	4.1.4.б гэсэн заалтыг байхгүй болгох, Мөн энэ хуулинд Хамтран амьдрагч гэсэн үгийг огт тусгамааргүй байна. Энэ үнэхээр гэр бүлийг дэмжиж л байгаа бол хоёрдмол утгыг байхгүй байлгах хэрэгтэй. Мөн хөрөнгө хуваах дээр хамтран амьдрагч болон түүнээс төрсөн хүүхдийг оруулахгүй байлгах ийм заалт хууль байгаа учраас гэр бүлээс гадуурх харилцаа хэвээр л байсаар л байх болно. Бас гэр бүлийн гишүүдийн аль нэг гишүүн нь өөр хүнтэй явалдсан бас хүүхэд төрүүлсэн бол зөрчил гаргаагүй гишүүндээ тодорхой мөнгөн торгууль нөгөөдөө олгодог байлгах талаар энэ хуулинд тусгамаар байна.	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
25	Х.Оюун-Эрдэнэ	Гэр бүлийн хуульд хуурч байгаа хамт хуурах нөхцөл үйлдсэн эр эм этгээд аль алинаас нь сэтгэлзүйн хохирлын хэмжээг авах заалт бас баймаар байна	Хохирол нэхэмжлэх зохицуулалтыг тусгасан.
26	Б.Оюунбилэг	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн төсөлд дараах 4 зүйл дээр дэмжих санал өгч байна. Мөн хуулийн төслийн 47-р зүйл дээр Гэрлэлтээ батлуулсан эхнэр, нөхөр нь эрүүл мэндийн шалтгаанаас байнгын асаргаанд орсон, хөдөлмөрийн чадвараа алдсан, өвдсөн г.м үед тэжээн тэтгэх үүргээсээ зугтах, үл хайхрах, хаяж явах, Сэтгэл санааны хүнд дарамтанд оруулах, гэсэн тохиолдолд мөн хүлээх хуулийн хариуцлагыг тодотгож оруулмаар санагдаж байна. 1. “Гэрлэлт бүртгэх 6.1 зүйл”, 2. “Гэрлэгчид бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэг 46 зүйл”, 3. “Гэрлэлтээ цуцлуулсан нөхөр эсхүл эхнэрийн тэжээн тэтгүүлэх эрх 47 зүйл”, 4. “Эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг 48 зүйл”... Та бүхний ажилт амжилт хүсье.	Саналыг тусгасан.
27	Д.Отгоннасан	Монгол Улсад шүүх болох төрийн байгууллагын ачаалал их, иргэдийг чирэгдүүлэх, хугацаа их орох зэрэг асуудал гардаг тул “гэрлэлтийг нотариатад бүртгүүлэх болон гэр	Иргэний улсын бүртгэлийн байгууллага тус чиг үүргийг

		бүлийн гишүүд бие биенээ тэжээн тэтгэх тухай гэрээг нотариатаар гэрчлүүлэх, түүнийг үндэслэн нотариатын мэдэгдэх хуудас бичих, шүүх тухайн асуудлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх" талаар заалтыг хуулийн төсөлд оруулж, нотариатын үйл ажиллагааг иргэдэд улам ойр байлгах нь ач холбогдолтой байна.	хариуцахаар тусгасан.
28	Алтанчимэг	Гэрлэгчидийн бүртгэл, гэрлэлтийн гэрээ,тэжээн тэтгэх гэрээнүүдийг талуудын хүсэлтээр нотариат гэрчлэж болох тухай заалтуудыг оруулж өгөх нь ач холбогдолтой болно. Гэрлэгчидийн хооронд эд хөрөнгийн маргаан гарахаас сэргийлэх,гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах г.м. Иймд хуулийн 6,46,47,48 р зүйлүүдэд дээрхи заалтуудтай холбоотой нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж өгөхийг хүсье.	Саналыг тусгасан.
29	Л.Хишигшинэн	Нотариатын чиг үүрэгт /гэр бүл, гэрлэгчид-н / тусгагдсан заалтуудыг бүхэлд нь дэмжиж байна.	Саналыг тусгасан.
30	Алтанзогсоол	Дэмжиж байна.	Дэмжсэн
31	Э.Шижиртуяа	"Гэр бүлийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Нэг. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу эрх бүхий төрийн байгууллагад биеэр хүрэлцэн ирж, гэрчийн этгээдийг байлцуулан бүртгүүлнэ" гэж заасныг "Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад биеэр хүрэлцэн ирж, гэрчийн этгээдийг байлцуулан бүртгүүлнэ" гэж өөрчлөн найруулах. Гэрлэгчид сайн дурын үндсэн дээр бие биенээ сонгож, хамтын амьдралаа эхлүүлснээ улсын бүртгэлд бүртгүүлж буй үйл явц тул гэрлэлтийг нотариатч бүртгэх боломжтой. Нотариатын тухай хуулийн 251.1-д "Танхим нь нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нотариатын үйл ажиллагаатай холбогдох бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлэх бөгөөд хуулиар хориглоогүй мэдээ, мэдээллийг улсын бүртгэл, татварын	Иргэний улсын бүртгэлийн байгууллага тус чиг үүргийг хариуцахаар тусгасан.

		болон бусад холбогдох байгууллагад цахим хэлбэрээр дамжуулж, харилцан мэдээлэл солилцоно.”, 251.2-т “Нотариатч нь гэрчилсэн үйлдэл бүрээр цахим бүртгэл хийх, мэдээлэл үүсгэх, санд байршуулах, баяжуулах, улсын бүртгэл, татварын болон холбогдох бусад байгууллагад дамжуулах, лавлагаа, мэдээлэл авах, зуучлах замаар нотариатын цахим үйл ажиллагаа эрхэлнэ.” гэж заасны дагуу гэрлэлтийг бүртгэх, бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад илгээх эрх зүйн орчин бүрдсэн юм. Мэргэшсэн, цомхон бүтэцтэй, өөрийн тодорхой чиг үүргээ төрийн бус мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх нь төрийн зөв бодлогын нэг хэсэг юм. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг тогтвортой, урт хугацаанд хэрэгжүүлэх үүднээс нийгмийн хөгжил, залуусын чиг хандлага, тэдгээрийн хүсэл зоригт нийцсэн хэм хэмжээг хуульчлах нь зүйтэй. Залуусын амьдралын хэв маяг, соёл өөрчлөгдөж буй энэ үед олон улсад гэрлэлтээ сүм, хийд болон нотариатад бүртгүүлэх хандлага дэлгэрч байна. Гэрлэлтийг заавал төрийн албан хаагч буюу улсын бүртгэгч бүртгэх гэхээс илүүтэйгээр гэрлэгчид хаана бүртгүүлэхээ өөрсдөө сонгож, нотариатад бүртгүүлбэл гэрлэгчдийн эрх, үүрэг, хариуцлагын талаар зөвлөгөө авч, гэрлэлтээ бүртгүүлж, гэрлэлтийн гэрээгээ гэрчлүүлэх нөхцөл, боломж бүрдэнэ. Энэ нь гэр бүл тогтвортой байх, гэрлэгчид гэр бүлийнхээ өмнө хүлээх үүргээ ухамсарлахад эергээр нөлөөлөх, эрх зүйн соёл бий болж төлөвшихөд үр нөлөөтэй. Мөн гэрлэгчдийн хооронд эд хөрөнгө, түүний эрхийн маргаан гарахаас урьдчилан сэргийлэх, хэрэв гарсан тохиолдолд гэрлэлтийн гэрээг үндэслэн шийдвэрлэх, гэр бүлийн гишүүдийн эрхийг адил тэгш хамгаалах эрх зүйн орчин бүрдсэнээр энэ төрлийн хэрэг, маргаан буурах чухал ач холбогдолтой юм. Хоёр. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 46 дугаар зүйлд 46.3, 46.4 дэх	

		хэсгийг нэмж оруулах. 46.3-т “Гэрлэгчид тэжээн тэтгэх тухай гэрээг нотариатаар гэрчлүүлж болох бөгөөд түүнийг үндэслэн тэтгэлэг авагчийн хүсэлтээр нотариатын мэдэгдэх хуудас үйлдэнэ.” 46.4-т “Энэ хуулийн 46.3-т заасан нотариатын мэдэгдэх хуудсанд заасан төлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гаргуулна.” Гурав. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 47 дугаар зүйлийн гарчгийг дараах байдлаар томьёолох. “Гэрлэлтээ цуцлуулсан нөхөр эсхүл эхнэрийн тэжээн тэтгүүлэх эрх” Дөрөв. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 47 дугаар зүйлд 47.2, 47.3 дахь хэсгийг нэмж оруулах, 47.2 гэснийг 47.4 гэж өөрчлөх. 47.2-т “Энэ хуулийн 47.1.1-д заасан тохиолдолд талууд тэжээн тэтгэх тухай гэрээг нотариатаар гэрчлүүлж болох бөгөөд түүнийг үндэслэн тэтгэлэг авагчийн хүсэлтээр нотариатын мэдэгдэх хуудас үйлдэнэ.” 47.3-т “Энэ хуулийн 47.2-т заасан нотариатын мэдэгдэх хуудсанд заасан төлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гаргуулна.” Тав. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 48 дугаар зүйлд 48.5, 48.6 дахь хэсгийг нэмж оруулах. 48.5-д “Энэ хуулийн 48.1-д заасан үүргийг биелүүлэх тэжээн тэтгэх тухай гэрээг талууд нотариатаар гэрчлүүлж болох бөгөөд түүнийг үндэслэн тэтгэлэг авагчийн хүсэлтээр нотариатын мэдэгдэх хуудас үйлдэнэ.” 48.6-д “Энэ хуулийн 48.5-д заасан нотариатын мэдэгдэх хуудсанд заасан төлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гаргуулна.” Гэр бүлийн хамаарал бүхий хүмүүс бие биенийгээ тэжээн тэтгэх үүргийг хуульчилсан тул түүний биелэлтийг түргэн шуурхай хангуулах, нотариатаар гэрчлүүлсэн тэжээн тэтгэх тухай гэрээг үндэслэн нотариатч мэдэгдэх хуудас үйлдэж, шүүгч баталгаажуулах замаар энэ төрлийн хэрэг, маргааныг хялбаршуулан шийдвэрлэж, шүүхийн ачааллыг	

		бууруулах боломжтой. Түүнчлэн эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгөөрөө хохирохгүй байх, эрх тэгш байдлаа харилцан тохиролцож тогтоох давуу талтай. Иймд “нотариатаар гэрчлүүлсэн тэжээн тэтгэх тухай гэрээ”-г Гэр бүлийн тухай хуулийн холбогдох хэсэгт хуульчлах нь гэр бүлийн хэрэг, маргааныг шүүхийн бус журмаар хялбаршуулан шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх, талуудын хөндөгдсөн эрхийг цаг алдалгүй хамгаалж, нотариатчийн үүрэг, оролцоо нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийн харилцаанд тодорхой хувь нэмрээ оруулах хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.	
32	Х.Түмэн-Өлзий	1. “Гэрлэлт бүртгэх 6.1 зүйл”; 2. “Гэрлэгчид бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэг 46 зүйл”; 3. “Гэрлэлтээ цуцлуулсан нөхөр эсхүл эхнэрийн тэжээн тэтгүүлэх эрх 47 зүйл”; 4. Эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг 48 зүйл” эдгээр заалтуудад дараах саналыг өгч байна. Гэрлэлтийг нотариатад бүртгүүлэх болон Гэрлэлтийн гэрээ, гэр бүлийн гишүүд бие биенээ тэжээн тэтгэх тухай гэрээг нотариатаар гэрчлүүлэх, түүнийг үндэслэн нотариатын мэдэгдэх хуудас бичих, шүүх тухайн асуудлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зохицуулалтыг оруулах	Иргэний улсын бүртгэлийн байгууллага тус чиг үүргийг хариуцахаар тусгасан.
33	Одгэрэл	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэрлэлтийг нотариатад бүртгүүлэх болон гэр бүлийн гишүүд бие биенээ тэжээн тэтгэх тухай гэрээг нотариатаар гэрчлүүлэх, түүнийг үндэслэн нотариатын мэдэгдэх хуудас бичих, шүүх тухайн асуудлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх” боломжтой юм, Тодруулбал хуулийн 6,46,47,48-р зүйлүүдэд дээрх өөрчлөлтийг оруулах саналтай байна.	Саналыг тусгасан.
34	Э.Шижиртуяа	Монголын нотариатчдын танхимаас 2023 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр 811 дугаартай Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай албан бичгээр хүргүүлсэн саналыг бүхэлд нь оруулж өгөхийг дэмжиж байна.	Иргэний улсын бүртгэлийн байгууллага тус чиг үүргийг хариуцахаар тусгасан.
35	А.Намуун	Гэрлэлтийг нотариатад бүртгүүлэх гэр бүлийн гишүүд бие биенээ тэжээн	Иргэний улсын бүртгэлийн

		тэтгэх тухай гэрээг нотариатаар гэрчлүүлэх, түүнийг үндэслэн нотариатын мэдэгдэх хуудас бичих, шүүх тухайн асуудлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломж их байна. Шүүхийн ачаалал болон бүртгэлийн ачаалал асар их багасгах боломжтой байх тул тус хуулийн “Гэрлэлт бүртгэх 6.1 зүйл”; “Гэрлэгчид бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэг 46 зүйл”; “Гэрлэлтээ цуцлуулсан нөхөр эсхүл эхнэрийн тэжээн тэтгүүлэх эрх 47 зүйл”; Эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг 48 зүйл”; дээр нотариатаар гэрчлүүлэх боломжийг нэмж өгнө үү	байгууллага тус чиг үүргийг хариуцахаар тусгасан.
36	Наранцэцэг	Хуулийн төсөлд өгөх санал: Гэр бүл цуцлах гол шалтгаан болох гэр бүлээс гадуур харилцааг үл зөвшөөрч гэр бүл салалтын шалтгаан болж байгаа харилцаа үүсгэж байгаа субъектүүдэд хариуцлага тооцох механизмыг иж бүрнээр хуульд тусгуулж зөрчсөн этгээдэд өндөр хэмжээний торгуулийн арга хэмжээ авдаг байхаар хуульдаа тусгавал зүгээр байна.	Гэр бүлээс гадуурах харилцаанд хариуцлага асуудал нь хүний эрхийн зөрчих тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
37	Батсүх	Хуулийн 6, 46, 47, 48-р зүйлүүдийг нотариатаар гэрчлүүлдэг болгох саналтай байна	Иргэний улсын бүртгэлийн байгууллага тус чиг үүргийг хариуцахаар тусгасан.
38	Пүрэвдорж	Гэр бүл болохоосоо өмнө гэрлэлтийн гэрээгээ нотраатаар батлуулж хариуцлагжуулах хэрэгтэй гэр бүл салалт хэрээс хэтэрлээ. Бас араар тавилт, садар самууныг хумих хэрэгтэй бна	гэрлэлтийн гэрээгээ нотраатаар батлуулах саналыг тусгасан.
39	Б.Сутай	гэрлэлтийг нотариатад бүртгүүлэх гэр бүлийн гишүүд бие биенээ тэжээн тэтгэх тухай гэрээг нотариатаар гэрчлүүлэх, түүнийг үндэслэн нотариатын мэдэгдэх хуудас бичих, шүүх тухайн асуудлыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломж их байна. Шүүхийн ачаалал болон бүртгэлийн ачаалал асар их багасгах боломжтой байх тул тус хуулийн “Гэрлэлт бүртгэх 6.1 зүйл”; “Гэрлэгчид бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэг 46 зүйл”; “Гэрлэлтээ цуцлуулсан нөхөр эсхүл эхнэрийн тэжээн тэтгүүлэх эрх 47 зүйл”; Эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг 48 зүйл”;	Саналыг тусгасан.

		дээр нотариатаар гэрчлүүлэх боломжийг нэмж өгнө үү	

mojha.gov.mn/content/6525f94899e06106c644a4b8

Нүүр Өргөдөл гомдол Санал хүсэлт Гарын авлага Холбоо барих Мэдээ мэдээлэл Тарифын болон албаны нууц Нэвтэрсэн иргэдэд

MN 100

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ВИДНИЙ ТУХАЙ | ҮЙЛ АЖИЛЛАГАА | ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД | ЭРХ ЗҮЙН АКТ | ХУУЛИЙН ТӨСӨЛ | ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | ИЛ ТОД БАЙДАЛ | ШИЛЭН ДАНС

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

Нийтлэгдсэн огноо: 2023-10-10

Хуулийн төсөлд санал өгөх

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	Хавсралт файл
Төслийн файл	Харах
Үндэслэлийн тайлбар	Харах
Дэлгэрэнгүй танилцуулга	Харах
Товч танилцуулга	Харах
Шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох талаар судалгааны тайлан	Харах
Шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн үр нөлөөний үнэлгээний тайлан	Харах
Шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн зардлын тооцоо	Харах
Дагалдах хуулиуд	Харах